SBG SWISSBETTERGOLD

Swiss Better Gold Сангийн бодлого

1. SBG Сангийн ерөнхий танилцуулга ба зорилго 1
2. SBG Сангийн бүтэц 2
3. SBG Сангийн засаглал 3
4. SBG Сангийн техникийн туслалцаа 4
5. SBG Сангийн хамтын санхүүжилт 5
6. Сайн дурын хувь нэмэр 6
7. Төслийн санал хүргүүлэх 7
8. Үнэлгээний явц 8
9. Санхүүжилт олгох, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ ба тайлагнал 9
10. SBG Сангийн дэмжих баримтууд 10
11. Мэдээлэл харилцаа 10
12. Төслүүдийн жишээ 10

1. SBG Сангийн ерөнхий танилцуулга ба зорилго

Швейцарын Хариуцлагатай алтны холбооны сан (Swiss Better Gold Fund) нь SBG-ийн хөтөлбөрт хамрагдсан бичил, жижиг, дунд алт олборлогч уурхайнуудад нийгэм, байгаль орчны хэмжигдэхүйц сайжруулалтыг дэмжих, бодит үр нөлөө бий болгох зорилготой.

Сан дараах байдлаар ажиллана.

- Уул уурхайн бүс нутгуудад тогтвортой хөгжлийн төлөөх ахиц дэвшлийг хурдасгах зорилгоор нөлөө үзүүлэхүйц нийгэм, байгаль орчны төслүүдийг дэмжин хамтран санхүүжүүлэх.
- Үйлдвэрлэгчдэд SBG-ийн эх үүсвэрийн шалгуурыг хангаж, хадгалахад нь туслах зорилгоор онцлогт тохирсон техникийн туслалцаа үзүүлэх, хариуцлагатай алтны нийлүүлэлтийн сүлжээнд урт хугацаанд оролцох боломжийг бүрдүүлэх.

Хөтөлбөрт хамрагдсан бичил, жижиг, дунд алт олборлогч байгууллагуудад шууд дахин хөрөнгө оруулалт хийх нь SBG-ийн үндсэн тулгуур зарчмуудын нэг юм. SBG Сангаас санхүүжүүлсэн (хамтран) төслүүд нь SBG-ийн эх үүсвэрийн стратегийн үндсэн зарчмууд болох байгаль орчны хариуцлагатай менежмент, нийгмийн оролцоог хангах, хууль тогтоомжид нийцэж ажиллах зэргийг удирдлага болгодог. Үйлдвэрлэгчид нь эдгээр зарчмыг төсөл тус бүрийн төлөвлөлт, хэрэгжилтэд баримтлан ажиллах үүрэгтэй[1].

SBG-ийн тасралтгүй сайжруулалтын зарчмын дагуу Сангийн одоогийн бүтэц болон үйл ажиллагаа нь хамрах хүрээ болон үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд цаг хугацааны явцад шинэчлэгдэн хөгжиж болно.

[1] SBG-ийн шалгуур болон бодлогыг дагаж мөрдөхгүй байх нь үйлдвэрлэгчийг SBG хөтөлбөрөөс хасагдахад хүргэж болзошгүй.

SBG Сангийн Зорилгууд

SBG Сан нь нийлүүлэлтийн сүлжээний доод урсгал дахь SBG Холбооны гишүүн эцсийн худалдан авагчдын худалдан авалтаас санхүүждэг. Ингэснээр SBG Сан нийлүүлэлтийн сүлжээний тоглогчдоос оруулах хувь нэмрийг бодит болгох, SBG-ийн хөтөлбөрийн үр дүнтэй хэрэгжилтийг дэмжих, уул уурхайн байгууллагуудад тодорхой сайжруулалтыг бий болгох зэрэг боломжийг бүрдүүлдэг.

SBG Сан нь уялдаа бүхий гурван зорилготой:

- **Хөтөлбөр хэрэгжүүлэх:** SBG Сан нь SBG-ийн хөтөлбөрт тогтмол санхүүжилт олгодог бөгөөд техникийн туслалцаа, хяналт шинжилгээ, магадлан итгэмжлэл, хараат бус баталгаажуулалт зэрэг үндсэн үйл ажиллагааг газар дээр нь явуулах боломжийг бүрдүүлдэг.
- **Үйлдвэрлэгчийн нөлөөллийг дэмжих:** SBG Сан нь магадлан итгэмжлэгдсэн уурхайн үйлдвэрлэгчдийг стратегийн түвшинд дэмжиж, тэднийг SBG-ийн хөтөлбөрт идэвхтэй оролцохыг урамшуулдаг. Тус сан нь орон нутгийн иргэдийн амьжиргааг шууд дээшлүүлэх, байгаль орчны тогтвортой менежментийг сайжруулах, хариуцлагатай уул уурхайн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн нөлөөллийн төслүүдийг хамтран санхүүжүүлдэг.
- **Урт хугацааны үнэ цэний сүлжээний харилцаа:** SBG Сан уурхай болон эцсийн худалдан авагчдын хооронд урт хугацааны хамтын ажиллагааны бат бөх суурь тавих, түүнчлэн тогтвортой, хариуцлагатай, тэсвэрлэх чадвартай нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэхийг зорьдог.

2. SBG Сангийн бүтэц

<table>
<tr><th colspan="3">НИЙТ НӨЛӨӨЛЛИЙН УРАМШУУЛАЛ 1.35 US$</th></tr>
<tr><th>0.50 US$</th><th>0.70 US$</th><th>0.15 US$</th></tr>
<tr><th>Техникийн туслалцаа</th><th>Хамтын санхүүжилт</th><th>Үйл ажиллагаа</th></tr>
<tr><td>Үйлдвэрлэгчдэд SBG-ийн шалгуурыг хангах, хадгалахад нь үйлдвэрлэгчдийг дэмжиж, газар дээрх техникийн туслалцаа үзүүлэх</td><td>Магадлан итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчид болон/эсвэл ойр орчмын нутгийн иргэдэд үр өгөөжөө өгөх байгаль орчин, нийгэм болон засаглалын нөлөөллийн төслүүдийг хамтран санхүүжүүлэх</td><td>Холбооны үйл ажиллагаа, хараат бус баталгаажуулалт хийлгэхэд шаардлагатай SBG-ийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх</td></tr>
<tr><td colspan="3">Үйлдвэрлэгчдэд SBG-ийн шалгуурыг хангах, хадгалахад нь үйлдвэрлэгчдийг дэмжиж, газар дээрх техникийн туслалцаа үзүүлнэ.</td></tr>
<tr><th>1-р шат</th><th>2-р шат</th><th>3-р шат</th></tr>
</table>

SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүд үйлдвэрлэгчдэд SBG-ийн эх үүсвэрийн шалгуурыг хангаж, хадгалахад чиглэсэн техникийн туслалцааг газар дээр нь үзүүлдэг (1-р үе шат). Түүнчлэн техникийн туслалцааг техникийн тодорхой төслүүдийн хэлбэрээр хэрэгжүүлж болох бөгөөд эдгээр нь 1-р шат дахь үйлдвэрлэгчдийн SBG-ийн эх үүсвэрийн шалгуурыг хангах үйл явцыг хурдасгахад чиглэнэ (тасралтгүй сайжруулалтын үйл явц[2]).	SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүд үйлдвэрлэгчдэд SBG-ийн эх үүсвэрийн шалгуурыг хангаж, хадгалахад чиглэсэн техникийн туслалцааг газар дээр нь үзүүлдэг (2-р шат).	Үйлдвэрлэгчдийг SBG-ийн эх үүсвэрийн шаардлагад нийцэж буй эсэхэд тавих хяналт дэмжлэгийг үргэлжлүүлэх (1 ба 2-р шат)
Магадлан итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчид болон/эсвэл ойр орчмын нутгийн иргэдэд үр өгөөжөө өгөх **байгаль орчин, нийгэм болон засаглалын нөлөөллийн төслүүдийг хамтран санхүүжүүлэх**		
1-р шат	**2-р шат**	**3-р шат**
Хамааралгүй.	Бүрдүүлсэн урамшууллаар магадлан итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчид болон/эсхүл ойр орчмын нутгийн иргэдэд үр өгөөжтэй байгаль орчин, нийгэм, засаглалын төслүүдийг хамтран санхүүжүүлэх	Бүрдүүлсэн урамшууллаар магадлан итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчид болон/эсхүл ойр орчмын нутгийн иргэдэд үр өгөөжтэй байгаль орчин, нийгэм, засаглалын төслүүдийг хамтран санхүүжүүлэх
Холбооны үйл ажиллагаа, хараат бус баталгаажуулалт хийлгэхэд шаардлагатай **SBG-ийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх**		
Сангийн энэхүү хэсэг нь магадлан итгэмжлэгдсэн нийлүүлэгчдийн хараат бус баталгаажуулалтын зардлаас гадна Холбооны захиргааны зардал, тухайлбал ажилтнууд, харилцаа холбоо, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зардлуудын тодорхой хэсгийг нь санхүүжүүлэхэд зориулагдана.		

3. SBG Сангийн засаглал

SBG Сангийн ерөнхий удирдлагыг SBG-ийн Удирдах зөвлөл хэрэгжүүлнэ. SBG Сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг үр дүнтэй хангах хүрээнд УЗ нь Сантай холбоотой тодорхой үүрэг даалгаврыг УЗ-өөс томилогдсон гишүүдэд өгөх бөгөөд тухайн гишүүд нь **SBG Сангийн Хороог** бүрдүүлнэ. Хороо нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

- Хөтөлбөрийн хяналт, удирдлага: SBG Сангийн үйл ажиллагааг тодорхойлох, үнэлэх, тасралтгүй сайжруулах.
- Төслийн хяналт: Ирүүлсэн төслүүдийн саналыг үнэлэх, (шаардлагатай бол сайжруулах зөвлөмж өгөх), SBG болон SBG Сангийн ерөнхий зорилготой нийцэж буй эсэх, уул уурхайн үйл ажиллагаа болон тэдгээрийн ойр орчимд нийгэм, байгаль орчны хэмжигдэхүйц сайжруулалтыг дэмжих, бодит үр нөлөө бий болгож буй эсэхийг үнэлэх.

[2] Тодорхой нөхцөлд төслийн санхүүжилтийн техникийн туслалцааны хөрөнгийг үйлдвэрлэгчид 1-р шатанд хүрэхдээ эсвэл итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчид хэрэглэж болно. (Онцгой тохиолдлыг SBG Хороо хэлэлцэж шийдвэрлэнэ).

- Төсөл батлах: SBG Сангийн үнэлгээний шалгуурын (8-р хэсгийг үзнэ үү.) дагуу батлах, тодорхой нөхцөлтэйгээр батлах, эсвэл татгалзах. SBG Сангаас олгох дэмжлэг нь 25,000 ам.доллараас дээш байвал Удирдах зөвлөлөөр батлуулах.
- Удирдах зөвлөлд мэдээлэх: SBG Сангийн үйл ажиллагаа болон батлагдсан төслүүдийн талаарх мэдээллийг Удирдах зөвлөлийн улирал тутмын хуралд танилцуулах.

Үйл ажиллагааны түвшинд, уул уурхайн үйлдвэрлэгчидтэй шууд хамтран ажилладаг газар дээрх **хөтөлбөрийг хэрэгжүүлэгч баг нь** Сангийн хэрэгжилтийг дэмжин ажилладаг. Тэдний үндсэн чиг үүрэг нь:

- Үйлдвэрлэгчдэд хэрэгжүүлэх боломжтой төслийг тодорхойлоход нь туслах.
- Төслийн үзэл баримтлал болон төслийн бичиг баримтыг боловсруулахад нь дэмжих (үйлдвэрлэгчийн хүсэлтээр).
- Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх (үйлдвэрлэгчийн хүсэлтээр).
- Төслийн үр дүнг хянах, үнэлэх.
- Төслүүдээс шаардлагад нийцсэн тайлан хүлээн авах.

Түүнээс гадна, хэрэгжилтийн баг төслийн саналуудыг Хороонд танилцуулж, тухайн төслүүд үнэлгээний шалгуурт нийцэж буй эсэхийг хянахад дэмжлэг үзүүлнэ.

SBG Сантай холбоотой аливаа санал, гомдлыг Сангийн хэрэгжилтийн ажилтнуудад мэдэгдэх эсвэл SBG-ийн цахим хуудсанд байрлах санал гомдол хүлээн авах системээр дамжуулан гаргаж болно.

4. SBG Сангийн техникийн туслалцаа

SBG нь уул уурхайн үйлдвэрлэгчдэд **бүхий л төрлийн техникийн туслалцаа** үзүүлдэг. Үүнд, SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүдийн явуулдаг тасралтгүй хяналт шинжилгээ багтах бөгөөд сонирхлоо илэрхийлсэн, боломжит үйлдвэрлэгчдийг тодорхойлох, SBG-ийн эх үүсвэрийн шалгууртай харьцуулан гүйцэтгэлийн түвшнийг нь үнэлэх зорилгоор зөрүүний шинжилгээ хийх, үйлдвэрлэгчдийг эдгээр шалгуурыг хангаж, нийцлийг тогтвортой хадгалж ажиллахад нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мөн магадлан итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчдэд тогтмол хяналт, шинжилгээ хийж, урт хугацаанд тасралтгүй дэмжин ажиллах зэрэг багтана.

Эдгээр санхүүжилтээр SBG нь техникийн туслалцааны төслүүдийг (зөвлөх үйлчилгээний) хэрэгжүүлж болох ба 1-р шатны үйлдвэрлэгчдийг тасралтгүй сайжруулалтын үйл явцаар 2-р шат руу дэвшиж, шалгуурт нийцэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Уг төслүүд нь тухайн үйлдвэрлэгчийн тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөөнд тодорхойлсон зөрүүг арилгах зорилготой. Үйлдвэрлэгчид анхны зөрүүгийн шинжилгээг хийсний дараа SBG-ийн хэрэгжүүлэгч түнштэй хамтран зөвлөх үйлчилгээний хэрэгцээ, шаардлага, техникийн туслалцааны төслөө тодорхойлох ёстой.

Техникийн туслалцааны төслүүд нь SBG Холбоо болон үйлдвэрлэгчийн оролцоонд суурилна. Холбоо нь тухайн төсөлд батлагдсан санхүүжилтийг олгох бөгөөд үйлдвэрлэгчийн зүгээс үйл ажиллагааны цар хүрээ, хүчин чадалд дүйцэх хэмжээгээр ажиллах хүч, тоног төхөөрөмж болон бусад нөөцийг мөнгөн бус хэлбэрээр оруулж, төслийг хэрэгжүүлнэ. Энэхүү хувь хэмжээг тухайн төслийн онцлогийг харгалзан

үйлдвэрлэгч, SBG Сангийн хэрэгжүүлэх баг болон Хороо харилцан тохиролцоно.

SBG-ийн техникийн туслалцаа нь эв санааны нэгдлийн зарчимд суурилсан дэмжлэгийн механизм бөгөөд хөтөлбөрт хамрагдаж буй уул уурхайн бүх үйлдвэрлэгчид нөөцөөс үр шим хүртэх боломжтой.

5. SBG Сангийн хамтын санхүүжилт

SBG Сангийн санхүүжилтийн хувийг бүрэн магадлан итгэмжлэгдсэн (2-р шат) үйлдвэрлэгчдээс ирүүлсэн төслийн саналд үндэслэн дараах зорилгоор хуваарилна. Үүнд:

- Уул уурхайн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм, засаглалын арга туршлагыг SBG-ийн эх үүсвэрийн шалгууруас давуулж сайжруулах, мөн уул уурхайн байгууллагуудын тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд хамтын санхүүжилт олгох;
- Үйлдвэрлэгчдийн орон нутгийн оролцогч талуудтай хамтран тодорхойлсон олон нийтийн төслүүдийг дэмжих замаар уул уурхайн бүс нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах.

Эдгээр санхүүжилт нь **хамтын санхүүжилтийн урамшууллын** хэлбэрээр хэрэгждэг. Энэ хүрээнд алт нийлүүлэгч үйлдвэрлэгчид нь SBG Сантай хамтран байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээрх төслүүдэд өөрсдийн хувь нэмэр, хөрөнгө оруулалтыг оруулна. Стандарт дүрмийн[3] дагуу нийт зардлыг 50:50 харьцаатай хамтран санхүүжүүлнэ.

Тодруулбал, SBG нь дараах зорилгуудын аль нэг, эсвэл хэд хэдэн[4] зорилгуудад нийцсэн төслүүдийг дэмжин санхүүжүүлдэг.

- **Тогтвортой хөгжлийн зорилгуудын (ТХЗ)** нэг буюу хэд хэдэн зорилгод нийцсэн байх.
- Чадавх бэхжүүлэх, засаглалыг сайжруулах, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээнд нийцүүлэх замаар бичил уурхайн үйлдвэрлэгчдийн **мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн хандлагыг хөгжүүлэх, албажуулалтыг ахиулах**.
- Бохирдлыг бууруулах, хог хаягдлын хариуцлагатай менежментийг хэрэгжүүлэх, нөөцийн ашиглалтыг оновчтой болгох арга замаар **байгаль орчны эрсдэлийг хэмжигдэхүйц байдлаар бууруулах**.
- **Тогтвортой нөөцийн менежментийг дэмжих**, ялангуяа бохирдлыг бууруулах, уул уурхайн үйл ажиллагаанд нэн чухал үүрэгтэй ус болон бусад байгалийн нөөцийг үр ашигтай, хүртээмжтэй ашиглах.

[3] Онцгой нөхцөл үүссэн болон/эсхүл нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь SBG хөтөлбөрийн хүлээлтээс доогуур эсвэл давсан зэрэг онцгой тохиолдлыг Удирдах зөвлөл авч хэлэлцэнэ. (Жишээлбэл, хөдөлмөрийн нөхцөлийг мэдэгдэхүйц сайжруулахын зэрэгцээ бүтээмжийг нэмэгдүүлэх тодорхой үр өгөөжтэй төслийн хувьд SBG Сангийн санхүүжилтийн хувийг өөрөөр тогтоох боломжийг Холбоо хэлэлцэн шийдвэрлэж болно).

[4] Олон нийтийн төслүүд нь нэн тэргүүнд эмзэг бүлгийн хүн амыг дэмжихэд чиглэсэн байх бөгөөд ялангуяа эмэгтэйчүүд, залуу үе, уугуул иргэд болон нийгмийн бусад ялгаварлагдсан бүлгүүдэд онцгой анхаарна. Түүнчлэн эдгээр төслүүд нь орон нутгийн оролцогч талуудын оролцоог хангах, хүртээмжтэй, ил тод арга барилыг хэрэгжүүлэх, олон нийтийн өөриймшлийг бий болгох, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байна.

- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартыг хэрэгжүүлэх, уурхайн талбай дахь суурьшлын бүсийг сайжруулах, амралт чөлөөт цагийг зохистой өнгөрүүлэх боломжоор хангагдах, ажилчдын бие махбод, сэтгэл зүйн сайн сайхан байдлыг дэмжих замаар **уул уурхайн үйл ажиллагааны хөдөлмөрийн нөхцөл, амьдралын чанарыг ерөнхийд нь дээшлүүлэх**.
- Эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц, эдийн засгийн хүртээмжтэй боломжуудад хөрөнгө оруулалт хийх, амьдрах нөхцөлийг сайжруулахад чиглэсэн орон нутгийн иргэдийн санаачилгыг дэмжих замаар **нутгийн иргэдийн амьдралын чанарыг ерөнхийд нь дээшлүүлэх**.
- Тогтвортой газар ашиглалт, тогтвортой хөдөө аж ахуй, ойжуулалт, гамшгийн эрсдэлийг бууруулах стратеги зэрэг орон нутгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий байдлыг бууруулахад чиглэсэн санаачилгыг дэмжих замаар **уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх**.

Төслийн саналуудыг батлахдаа SBG Сангийн үнэлгээний шалгуурын (8 дугаар хэсгийг үзнэ үү) дагуу үнэлнэ.

Алт нийлүүлэгч үйлдвэрлэгч бүр SBG-ийн хамтын санхүүжилтийг ашиглах санал болгож буй хугацаа нь урамшуулал үүссэн өдрөөс хойш 24 сар байхыг анхаарах хэрэгтэй. Хэрэв тухайн үйлдвэрлэгч энэ хугацаанд байгаль орчин, нийгэм, засаглалын тодорхой төслийн санал ирүүлээгүй бол Удирдах зөвлөлийн шийдвэрээр тухайн хөрөнгийг SBG-ийн техникийн туслалцааны санхүүжилтэд дахин хуваарилж болно. Гэсэн хэдий ч төсөл нь илүү их хэмжээний санхүүжилт шаардсан тохиолдолд үйлдвэрлэгч урамшууллаа авахгүйгээр урт хугацаанд хуримтлуулж болно. Энэ тохиолдолд үйлдвэрлэгч дээрх хугацаа дуусахаас өмнө SBG Сангийн Хэрэгжилтийн ажилтанд хүсэлтээ (төлөвлөж буй төслийн саналаа) хүргүүлнэ. Уг хүсэлтийг SBG Сангийн Хороо хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв үйлдвэрлэгч SBG хөтөлбөрөөс гарсан, эсвэл урамшууллыг хугацаандаа ашиглаагүй бол тухайн хөрөнгийг 24 сарын дараа SBG-ийн техникийн туслалцааны санхүүжилтэд дахин хуваарилна.

6. Сайн дурын хувь нэмэр

SBG Холбооны гишүүд уул уурхайн үйлдвэрлэгчдийн тасралтгүй сайжруулалтын үйл явцыг дэмжих зорилгоор нэмэлт урамшуулал болгон өөрийн шийдвэрээр хөтөлбөрт хамрагдаж буй тодорхой үйлдвэрлэгчдэд үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, аль шатанд байгаагаас үл хамааран сайн дурын хувь нэмэр өгч болно. Сайн дурын хувь нэмрийг хөтөлбөрийг ерөнхийд нь дэмжихэд (тусгайлан заахгүйгээр), эсвэл зарим үйлдвэрлэгч(д)-ийн хэрэгцээ болон тухайн гишүүний сэдэл зорилгод нийцүүлэн Холбооны Нарийн бичгийн дарга нарын газартай хамтран тодорхойлсноор олгож болно. Энэхүү боломж нь гишүүдийн хоёр ангилалд адил нээлттэй боловч SBG-ийн зорилгыг дэмжих үүднээс дэмжигч гишүүдийг компанийнхаа хэмжээтэй уялдуулан сайн дурын хувь нэмэр оруулахыг уриалдаг. Эдгээр хувь нэмэр нь аливаа худалдан авалт хийх эсвэл тодорхой мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай уялдуулан олгогддоггүй.

Нэгдүгээр шатанд хамрагдаж буй уурхайгаас алт худалдан авдаг Холбооны нийлүүлэгч гишүүдийг SBG-ийн шаталсан шалгуурын зөрүүг арилгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор SBG-ийн техникийн туслалцааны үйл ажиллагаанд грамм тутамд 0.50 ам.долларын хэмжээтэй сайн дурын хувь нэмэр өгөхийг дэмждэг.

Энэхүү техникийн туслалцааны урамшууллыг 1-р шатны худалдан авалтад (ихэвчлэн масс балансын аргачлалын дагуу) эсвэл тухайн гишүүн болон SBG-ийн хамтран тогтоосон бусад шалгуурын дагуу ашиглаж болно.

Сайн дурын хувь нэмэр нь хандивлагч гишүүний компанийн нийгмийн хариуцлагын бодлого, буяны үйлсийн зарчим, эсвэл SBG-ийн хэрэгцээ, зөвлөмжтэй нийцсэн бусад зорилго, сэдэлд үндэслэнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг *"Компанийн гишүүнчлэлийн нөхцөл"* баримт бичгийн 2 дугаар хуудсаас үзнэ үү.

7. Төслийн санал хүргүүлэх

Төслийн саналыг SBG Сангийн Хороонд уул уурхайн үйлдвэрлэгч шууд эсвэл SBG Сангийн Хэрэгжилтийн ажилтнаар дамжуулан хүргүүлнэ. SBG Сангийн санхүүжилт авахын тулд үйлдвэрлэгч дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

1. Үйлдвэрлэгч байгууллагын Удирдах зөвлөл болон/эсвэл хууль ёсны төлөөлөгчийн гарын үсгээр баталгаажуулсан SBG төслийн саналын маягт (SBG-ээс баталсан стандарт маягтыг ашиглана). 50,000 ам.доллараас дээш үнийн дүнтэй санхүүжилт хүссэн тохиолдолд төслийн саналд тухайн уул уурхайн байгууллагын эрх бүхий хоёр төлөөлөгч гарын үсэг зурсан байна.
2. Төслийн саналын маягтад тухайн уул уурхайн байгууллагаас төслийн төлөвлөлт, хэрэгжилтийг хариуцан ажиллах ажилтныг тодорхой заасан байна.
3. SBG Холбооноос санхүүжилтийг ам.доллараар шилжүүлэх үйлдвэрлэгчийн банкны дансны мэдээлэл (хүлээн авагчийн нэр, хаяг, банкны нэр, хаяг, дансны дугаар, хүчин төгөлдөр SWIFT/BIC код). Банкны данс нь үйлдвэрлэгчийн нэр дээр эсвэл өөр хууль ёсны эсвэл албан ёсны төлөөлөгчийн нэр дээр байж болно. Сүүлийн тохиолдолд үйлдвэрлэгч нь Удирдах зөвлөл эсвэл өөр хууль ёсны эсвэл албан ёсны төлөөлөгчийн (данс эзэмшигч байж болохгүй) гарын үсэг бүхий албан бичгийг ирүүлэх шаардлагатай бөгөөд үүнд санхүүжилтийг тухайн дансанд шилжүүлэхийг зөвшөөрч, хөрөнгийг төслийн саналд заасан зориулалтын дагуу эцсийн байдлаар ашиглахаа мэдэгдэнэ. Хэрэв данс эзэмшигч нь уул уурхайн үйлдвэрлэгчээс өөр этгээд байвал SBG тухайн дансны хүлээн авагчийг магадлан шалгах эрхтэй.
4. SBG-ийн хамтын санхүүжилт авахын тулд магадлан итгэмжлэгдсэн уул уурхайн үйлдвэрлэгч болон SBG-ийн хороонд Хамтын ажиллагааны гэрээ байгуулна.

Уул уурхайн үйлдвэрлэгчид төслийн саналаа боловсруулахдаа SBG Сангийн үнэлгээний шалгуурт (8 дугаар хэсгийг үзнэ үү) нийцүүлэх зорилгоор SBG-ийн Хэрэгжилтийн ажилтнуудтай эхнээс нь хамтран ажиллахыг зөвлөж байна. Шаардлагатай тохиолдолд SBG Сангийн Хороо үйлдвэрлэгчээс дэлгэрэнгүй мэдээлэл, тодруулга шаардаж болно. Түүнчлэн SBG нь Сангийн бусад төслүүд болон Холбооны гишүүдийн төслүүдийн хүрээнд өргөн салбарыг хамарсан холбоо харилцаатай. Иймд үйлдвэрлэгч болон SBG аль аль нь хэрэгтэй гэж үзсэн тохиолдолд тухайн сонирхож буй үйлдвэрлэгчийг ижил төстэй бусад төслүүдтэй холбож, харилцан туршлага солилцох боломж олгодог.

Төслийн хэмжээнээс үл хамааран тендер шалгаруулалт зохион байгуулах, мөн төслийн мэргэжлийн хяналт тавихыг зөвлөдөг. Төслийн нийт зардал 100,000 ам.доллартай тэнцүү буюу түүнээс дээш тохиолдолд дээрх шаардлагыг заавал биелүүлэх ёстой бөгөөд төслийн саналын хамт Хороонд хүргүүлнэ.

8. Үнэлгээний явц

SBG Сангийн зорилготой нийцлийг хангах, төслийг батлах үйл явцыг ил тод хэрэгжүүлэх зорилгоор төслийн саналыг дараах үнэлгээний **шалгуурын** дагуу үнэлнэ.

Шалгуур	**Зорилго**
SBG Сангийн бодлогод тусгасан зорилгуудын аль нэг, эсвэл хэд хэдэн зорилгод нийцсэн байх	Төсөл нь энэхүү Бодлогын 5 дугаар хэсэгт тодорхойлсон SBG-ийн хамтын санхүүжилтийн ерөнхий зорилгуудтай хэрхэн нийцэж байгааг үнэлнэ.
Төслийн бүрэн үндэслэл, логик уялдааг хангасан байх	Төслийн санал нь тодорхой, уялдаа холбоотой, хангалттай нарийвчилсан логик үндэслэлтэй эсэх, мөн төлөвлөсөн үйл ажиллагаа нь төслийн зорьж буй үр дүнд хэрхэн хүргэх зэргийг үнэлнэ.
SBG-ийн эх үүсвэрийн шалгуурын хүрээнд тасралтгүй сайжруулалтад хувь нэмэр оруулах	Төслийн санал нь SBG-ийн эх үүсвэрийн шалгуурыг боловсронгуй болгоход хэрхэн хувь нэмэр оруулахыг үнэлнэ.
Үйлдвэрлэгч төслийн 50 хувийг (мөнгөн болон эсвэл мөнгөн бус хэлбэрээр) хамтран санхүүжүүлэх чадвартай байх	Үйлдвэрлэгч нь SBG Сангийн хамтын санхүүжилтийн зарчмын дагуу төслийн нийт зардлын 50 хувийг мөнгөн болон/эсхүл мөнгөн бус хэлбэрээр хамтран санхүүжүүлэх нөөц бололцоотой, хариуцлагатай эсэхийг үнэлнэ.
Төслийн үр нөлөөг хэмжих, хэрэгжилтийн явцыг хянах, үр дүнг үнэлэх тодорхой механизмыг тодорхойлох	Төслийн санал нь тодорхой шалгуур үзүүлэлт ашигласан зэрэг үр нөлөөг хэмжих, хэрэгжилтийн явцыг хянах, үр дүнг үнэлэх тодорхой бөгөөд тохиромжтой арга хэрэгсэл, механизмыг тусгасан эсэхийг үнэлнэ.
Дунд болон урт хугацааны хэтийн төлөвийг (тогтвортой байдал) авч үзэх	Төслийн санал нь дунд болон урт хугацааны төлөвийг тусгасан эсэх, тогтвортой үр дүнг хангахуйц хувь нэмэр байгаа эсэхийг үнэлнэ. Үүнд тухайн төсөл нь нэг үйлдвэрлэгчийн эсвэл өөр бусад төслүүдийн урт хугацааны зорилготой хэрхэн уялдах, өргөн хүрээний үр нөлөө үзүүлэх байдлыг авч үзэж болно.
Төслийн сургамж, сайн туршлагыг ижил болон бусад уурхайд өргөжүүлэн эсвэл давтан хэрэгжүүлэх боломжтой байх	Энэхүү шалгуур нь тухайн уул уурхайн байгууллагад төслийн дараагийн үе шатыг өргөжүүлэн хэрэгжүүлэх, эсвэл бусад уул уурхайд ижил загвараар давтан хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлнэ.
Нэмэлт шалгуурууд (шаардлагатай тохиолдолд)	
Төсөл нь иргэдийн оролцоог хангасан, хамтын ажиллагааг харуулсан орон нутгийн болон эсвэл байгаль орчны санаачилгад	Төслийн санал нь орон нутгийн болон байгаль орчны санаачилгуудтай нийцэж, орон нутгийн иргэдийн утга учиртай оролцоог хангасан эсэхийг үнэлнэ. Энэ нь уурхай болон орон нутгийн төлөөлөгчдийн хооронд байгуулсан албан ёсны

нийцэж буй эсэх	бичгээр үйлдсэн гэрээ, үүрэг амлалт, эсвэл бусад баримт, материалаар нотлогдсон байна.
Шаардлагатай зөвшөөрлүүд, холбогдох судалгаа болон техник, санхүүгийн баримт бичгийг төслийн төлөвлөлтөд тусгасан, эсвэл авч үзсэн эсэх	Холбогдох хууль тогтоомж, журмын дагуух нөхцөл шаардлагуудыг төслийн төлөвлөлтөд зохих ёсоор тусгасан эсвэл авч үзсэн эсэхийг үнэлнэ. Үүнд шаардлагатай зөвшөөрлүүд, холбогдох судалгаа, техникийн болон санхүүгийн баримт бичиг гэх мэт багтана.

Бүх төслийн саналыг SBG Сангийн Хороо үнэлнэ. Үнэлгээний дүнд үндэслэн Хороо төслийг батлах, нөхцөлтэйгээр батлах, эсвэл татгалзах шийдвэр гаргана. SBG Сангаас олгох санхүүжилтийн хэмжээ 25,000 ам.доллараас дээш бол Холбооны Удирдах зөвлөлөөр батлуулна. Энэ тохиолдолд Хороо зөвшөөрөл авахаар төслийн танилцуулгын хуудас болон үнэлгээний оноог Удирдах зөвлөлд хүргүүлнэ.

Хэрэв төсөл "нөхцөлтэйгөөр батлагдсан" бол Хорооноос үнэлгээний шалгуурт нийцүүлэн сайжруулах шаардлагатай асуудлуудын жагсаалтыг гаргана. SBG Сангийн хэрэгжилтийн баг нь үйлдвэрлэгчтэй хамтран сайжруулсан хэсгүүдийг төслийн саналд тусгана. Хэрэв "татгалзсан" бол SBG-ийн хэрэгжилтийн баг болон үйлдвэрлэгч төслийг бүхэлд нь дахин хянаж, төслийн үзэл баримтлалыг үндсэнд нь сайжруулах эсхүл өөр төсөл сонгох асуудлыг хэлэлцэнэ. Үнэлгээний оноо болон тухайн үнэлгээний үндэслэлийг үйлдвэрлэгчид хүргүүлэх бөгөөд эдгээр нь төслийн саналыг шинэчлэн боловсруулах суурь болно.

Төслийн саналыг хүлээн авсан өдрөөс хойш Хороо 2–3 долоо хоногийн дотор үнэлгээ хийж дуусгана. Хэрэв Удирдах зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай бол үйл явц хамгийн ихдээ 4 долоо хоног үргэлжилж болно. Үнэлгээний дүнг SBG Сангийн Хэрэгжилтийн ажилтнаар дамжуулан үйлдвэрлэгчид мэдэгдэнэ.

9. Санхүүжилт олгох, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ ба тайлагнал

Санхүүжилт олгох: Төсөл батлагдсаны дараа үйлдвэрлэгч болон SBG нь санхүүжилтийг нэг удаагийн шилжүүлгээр олгох эсэх, эсвэл урьдчилан тохиролцсон санхүүжилт олгох хуваарийн дагуу үе шаттайгаар шилжүүлэх эсэхийг харилцан тохиролцоно.

Хэрэгжүүлэх: Уул уурхайн үйлдвэрлэгч нь төслийн танилцуулах хуудаст тодорхойлсны дагуу төслийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Төслийн анхны саналд орсон аливаа өөрчлөлтийг SBG Сангийн Хэрэгжилтийн ажилтанд мэдэгдэж, үндэслэлийг танилцуулна. Төслийн төсөв нэмэгдсэн тохиолдолд уг нэмэгдлийг зохих ёсоор баримтжуулж, үндэслэлтэйгээр тайлбарласан бол хамтран санхүүжүүлэх боломжтой. Ерөнхийдөө уул уурхайн үйлдвэрлэгч болон SBG-ийн зүгээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд SBG хөтөлбөрийн хэрэгжилтийн ажилтан төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж болно.

Хяналт шинжилгээ ба тайлагнал: SBG нь SBG Сангаас санхүүжилт авсан төслүүдэд хяналт тавьдаг. Тиймээс төслийн санал бүр нь төслийн үр дүнг зохих ёсоор

үнэлэх боломж олгохуйц холбогдох үзүүлэлтүүдийг агуулсан байна. Эдгээр шалгуур үзүүлэлт нь төслийн онцлогоос хамааран богино, дунд эсвэл урт хугацааны байж болох бөгөөд Хэрэгжүүлэлтийн ажилтны уурхайн талбайд ажиллах гэх мэт хяналт, шинжилгээний үйл ажиллагаа багтаж болно. Төслийн явцын ба хэрэгжилтийн дараах хяналт шинжилгээг тухайн тохиолдол бүрт, уул уурхайн үйлдвэрлэгч болон Хэрэгжүүлэлтийн ажилтны хооронд тохиролцсоны дагуу тогтмол хянаж, тайлагнах ёстой. Ерөнхийдөө төсөл бүр хэрэгжилтийн явцад дор хаяж нэг явцын тайлан, мөн эцсийн тайлан гаргана. SBG-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийн ажилтнууд үйлдвэрлэгчийн хүсэлтээр эдгээр тайланг боловсруулахад дэмжлэг үзүүлж болно.

10. SBG Сангийн дэмжих баримтууд

- **SBG Сангийн төслийн танилцуулах хуудас:** төслийн саналд зориулсан
- **SBG Сангийн тайлангийн маягт:** хяналт, шинжилгээ ба тайлагналд зориулсан
- **SBG Сангийн төслийн каталоги:** өмнө нь дэмжигдсэн болон хэрэгжүүлэх боломжтой төслүүдийн эмхэтгэл бөгөөд уул уурхайн үйлдвэрлэгчдэд байгууллагадаа хэрэгжүүлэх боломжтой төслүүдийг тодорхойлоход туслах практик чиглэл, гарын авлага болох юм.

11. Мэдээлэл харилцаа

SBG нь SBG Сангийн хөрөнгийн зарцуулалт, хүрсэн үр нөлөө, ашиг шим хүртэгсэд, түүнчлэн Сангийн хөрөнгийг ашигласны үр дүнд бий болсон нийгэм болон/эсвэл байгаль орчны бусад сайжруулалтын талаар өөрийн гишүүд, түншлэгч уурхайнууд болон иргэний нийгмийн байгууллагуудад тогтмол мэдээлэл хүргэдэг. SBG нь зөвхөн бүрэн хэрэгжиж дууссан төслүүдийн талаар мэдээлэл өгдөг.

12. Төслүүдийн жишээ

SBG-ийн техникийн туслалцаа нь уул уурхайн үйлдвэрлэгчийг SBG-ийн шалгуур шаардлагыг хангахад нь төрөл бүрийн хэлбэрээр (энэхүү жагсаалтаар хязгаарлагдахгүй) дэмжлэг үзүүлж болно. Тухайлбал:

1. Хувийн хамгаалалтын хэрэгсэл (XXX) худалдан авах, хангах;
2. Аюултай бодистой (тэсрэх бодис, цианид, мөнгөн ус зэрэг) харьцах талаар аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах;
3. Цэвэр технологи нэвтрүүлэх (мөнгөн усны хэрэглээг бууруулах, халах);
4. Хог хаягдал, баяжуулалтын хаягдлын менежментийн чиглэлээр техникийн зөвлөгөө, сургалт зохион байгуулах;
5. Хөдөлмөрийн нөхцөл, олборлолт, боловсруулалт, баяжуулалтын явцыг сайжруулах, нүүрстөрөгчийн давхар ислийн (CO_2) ул мөрийг бууруулах зорилгоор олборлолт, баяжуулалтын тоног төхөөрөмж худалдан авах (Үүнд

сэгсрэгч ширээ, агааржуулалтын систем, эрчим хүчний өндөр үр ашигтай цахилгаан тоног төхөөрөмж гэх мэт);
6. Байгууллагын болон ерөнхий удирдлагын чадавхыг бэхжүүлэх;
7. Бодлого болон эсвэл бусад баримт бичгийг албажуулахад дэмжлэг үзүүлэх;
8. Үйл ажиллагааг бүрэн албажуулах, эсвэл албажуулалтын дараа шаардагдах зөвшөөрлүүдийг авах эсвэл сунгуулах, шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх;
9. Тодорхой чиглэлүүдээр сургалт зохион байгуулах (уурхайн ажилтнуудад зориулсан хүний нөөцийн сургалт; Эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох сургалт, нягтлан бодох бүртгэл гэх мэт);
10. Арилжааны суваг нээхэд захиргаа, удирдлагын түвшинд дэмжлэг үзүүлэх.

SBG Сантай хамтын санхүүжилтийн жишээнүүд (эдгээрээр хязгаарлагдахгүй):

1. Үйл ажиллагаа явуулж буй газрын ойр орчмын иргэдийг цахилгаан эрчим хүчээр хангах;
2. Уурхайн үйлдвэрлэлийн байгууламжид дизель түлш, шатахуун болон бусад төрлийн эрчим хүчний хэрэглээг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
3. Цэвэр усны хангамжийн хүртээмжийг сайжруулах;
4. Орон нутгийн иргэдэд зориулсан боловсролын төслүүд хэрэгжүүлэх (жишээ нь: сургалтын төвүүд, дижитал сургалт), эсвэл уурхайн ажилтнуудад зориулсан үйлдвэрлэлийн үйл явцыг сайжруулах техникийн сургалт г.м;
5. Тоглоомын талбай, амралт, чөлөөт цагийн бүс, эрүүл мэндийн болон анхны тусламжийн төв байгуулах, мөн уурхайн бүс хүрэх авто замыг шинэчлэх зэрэг орон нутгийн дэд бүтцийг сайжруулах;
6. Орон нутгийн иргэдэд үр өгөөж өгөхүйц газар тариалан, мал аж ахуй, тэдгээрийг дэмжих бусад дагалдах үйлдвэрлэл эрхлэх (малын вакцинжуулалт г.м);
7. Хуучин уурхайн талбайг ойжуулах эсвэл нөхөн сэргээх;
8. Баяжуулалтын хаягдлын менежментийг сайжруулах, жишээлбэл, хамгаалалтын далан барих г.м;
9. Албажуулах хөтөлбөрүүд;
10. Байгалийн гамшиг болон бусад онцгой байдлын үед ойр орчмын иргэдэд яаралтай тусламж үзүүлэх (жишээ нь хүнсний тусламж).

Санхүүжилтэд хамрагдахгүй зардал: Хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүрэгтэй холбоотой зардлууд (тухайлбал, цалин хөлс, тусгай зөвшөөрлийн төлбөр, гишүүнчлэлийн хураамж, хууль эрх зүйн зөвлөгөө); мөн батлагдсан төсөлд хамааралгүй техник эдийн засгийн үндэслэл гэх мэт.